



**BASALTWOOL®**  
**МОНГОЛ БАЗАЛТ ХК**



# 2021

**МОНГОЛ БАЗАЛТ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ**

## ❖ АГУУЛГА

- Мэндчилгээ
- ТУЗ-ийн тогтоол
- Хурлаар хэлэлцэх асуудал
- Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар хугацаа
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
- Хурлаар хэлэлцэх асуудлын дагуу илтгэл тавина
  1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт, хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах
  2. “Монгол базальт” ХК-ийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийн тайлбар
  3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга
  4. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, тогтоолын төсөл
- Хурлаас гарах тогтоолын төсөл
- Саналын хуудасны загвар

## ❖ МЭНДЧИЛГЭЭ

### МОНГОЛ БАЗАЛЫТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ!

“Монгол Базальт” ХК-ийн компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, дүрмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж, батлах асуудлуудыг хэлэлцэхээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг бэлтгэн хувьцаа эзэмшигчдэд хүргүүлж байна.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Монгол базальт” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
2. “Монгол базальт” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж, батлах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүдийг сонгох
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг батлах

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, “Фламинго таур”ийн 7 давхарт компанийн оффист ажлын өдрүүдэд 11.00-16.00 цагийн хооронд хүрэлцэн ирж танилцаж болно.

**❖ ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ  
БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ  
БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР,  
ХУГАЦАА**

Хувьцаа эзэмшигчид нь 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 11:00 – 16:00 цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэрын 7 давхарт ирж танилцаж болно.

*“Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2021 оны 03 сарын 15 өдрийн 05 тоот тогтоолын  
Хавсралт № 1*

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ  
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

<b>№</b>	<b>Баримт бичгийн жагсаалтууд:</b>
1	“Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн тогтоол Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай 2021.03.15-ны өдрийн Дугаар 05
2	“Монгол Базальт” ХК-ийн 2020 оны Санхүүгийн тайлан, Аудитын дүгнэлт
3	“Монгол Базальт” ХК-ийн 2020 оны Үйл ажиллагааны тайлан
4	“Монгол Базальт” ХК-ийн 2020 оны Үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлт
5	Компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид, түүний хувьцааны төрөл, тоо
6	Төлөөлөн удирдах зөвлөлийн Ногдол ашгийн тухай тогтоол 2021.02.08- ны өдрийн Дугаар 03
7	“Монгол Базальт” ХК-ийн дүрэм /шинэчилсэн найруулга/
8	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга
9	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээний төсөл

*“Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2021 оны 03 сарын 15-ний өдрийн 05 тоот тогтоолын  
Хавсралт № 2*

## “Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

“Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Монгол Базальт” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 сарын 26-ны өдрийн Даваа гаригт 16.00 цагт болох тул Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхнийг оролцохыг урьж байна.

Коронавируст халдварт өвчин /Ковид 19/-ний тархалттай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахдаа хувьцаа эзэмшигчдийг нэг дор цугларуулахгүйгээр буюу цахим хэрэгсэл ашиглан онлайн орчинд зохион байгуулах болно.

Хуралд оролцох цахим программын нэр: **MI SURVEY программ**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2021 оны 04 сарын 08-ны өдрөөр тасалбар болгоно.

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. “Монгол базальт” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
2. “Монгол базальт” ХК-ийн дүрэмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж, батлах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүдийг сонгох
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг батлах

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, “Фламинго тауэр”ийн 7 давхарт компанийн оффист ажлын өдрүүдэд 11.00-16.00 цагийн хооронд хүрэлцэн ирж танилцаж болно.

**Зар хүргэх мэдээллийн хэрэгсэл:**

1. Хөрөнгийн биржийн цахим сайт **www.mse.mn**
2. Монгол базальт ХК-ийн цахим сайт **www.basaltwool.mn**
3. Өдөр тутмын сонин: **Өдрийн сонин**
4. Радио эсхүл телевиз: **Радио fm 88.3**

## ❖ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Си Эм Си ХХК-ийн хөгжүүлсэн MI SURVEY программыг ашиглан цахим хэлбэрээр хийнэ.

Эрхэм хувьцаа эзэмшигч та орон зайнаас үл хамааран гар утас, таблет, компьютер ашиглан Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцохоор бүртгүүлж болно. Компани таны хүсэлтийг хүлээн авч хянасны үндсэн дээр таны гар утсанд программд нэвтрэх мэдээллийг хүргүүлнэ.

Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах дарааллаар явагдана. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэл, ирцийг мэдээлэх *15 минут*
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээх  
*/Хурлын дарга А.Энхгэрэл/ 10 минут*
3. Хурлаар хэлэлцэх асуудлын дагуу илтгэл тавина
  - 3.1 Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт, хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах *15 минут*
  - 3.2 “Монгол базальт” ХК-ийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийн тайлбар *10 минут*
  - 3.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга *5 минут*
  - 3.4 ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, тогтоолын төсөл *5 минут*
4. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт *3 минут*
5. Санал авах /цахим/ *10 минут*
6. Санал хураалтын дүнг нэгтгэн, танилцуулах *5 минут*
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, хурал хаах *5 минут*

## ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

❖ **МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ИЙН 2020 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД  
ӨГӨХ ДҮГНЭЛТ**

Монгол Базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2020 оны бизнес төлөвлөгөөний гол зорилго нь сүүлийн 4 жилийн хугацаанд үргэлжилж буй үндсэн технологийн дамжлагууд дээрх шинэчлэл бүтээн байгуулалтын капитал хөрөнгө оруулалтын ажлуудыг дүгнэн капиталжуулах, үүний сацуу үйлдвэрлэлийн бүтээмжийг ахиулах, бүтээгдэхүүний тоо хэмжээг төрөлжүүлэх, дотоодын борлуулалтын сувгуудын тогтолцоог сайжруулахад, чиглэсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллахад чиглэсэн билээ.

2020 онд дэлхий даяар тархсан Ковид-19 цар тахалд автаж, манай улсын эдийн засаг, ААН-үүдийн үйл ажиллагаа улс даяар доголдсон хүнд жилтэй нүүр тулсан билээ. Монгол Базальт компани нь хамгийн багадаа 6.7 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллах төлөвлөгөөтэй оныг эхлүүлсэн хэдий ч сүүлийн хагас жилийн хөл хорионы нөхцөл байдалтай холбогдуулан алдагдсан боломжийн орлого үүсч 3.1 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж үнэт цаасны танилцуулга дээрх төлөвлөгөөний биелэлт 47%, өмнөх оноос цэвэр ашиг 2%-иар буурсан хэдий ч, компанийн хүрээнд алдагталтай ажиллаагүйн сацуу, онцгой нөхцөл байдлын үеийн эрсдэлийн төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлснээр ББӨ-г 3%-иар бууруулан жилийн эцсээр ашигтай ажилласан гүйцэтгэлтэй байна.

Монгол Базальт ХК нь сүүлийн 4 жилийн хугацаанд үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 10 орчим тэрбум төгрөгийн капитал хөрөнгө оруулалт хийж, үүний 48%-г татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтаараа, үлдсэн 52%-г компани өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлж ажилласан байна. Үйлдвэрлэлийн гарц, чанар, бүтээгдэхүүний нэр төрөл олширч, цаашид зах зээлийн тэлэлт хийхэд бүрэн бэлэн болсон байна.

Иймд Монгол Базальт ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2020 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

**МОНГОЛ БАЗАЛЫТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

❖ **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС  
ГИШҮҮНД:**

1. Шаравсамбуу ЭНХТӨР
2. Чансаа ЗОРИГТБААТАР
3. Түвшинтөрийн ЦЭНД-АЮУШ
4. Пүрэвсүх НЯМДОРЖ

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД:**

1. Лхагважав АРИУНБОЛД
2. Галбадрах ГАНЗОРИГ
3. Ариунболд ЭНХГЭРЭЛ
4. Пүрэвбанзрагч САЙНБИЛЭГ
5. Бадарч ШАРАВСАМБУУ
6. Хан Гю Бунг /Han Kyu Bong/



❖ **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ  
БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТОВЧ  
НАМТАР**



**ШАРАВСАМБУУ ЭНХТӨР**

**Мэргэжил:** Эрх зүйч, Банкны Удирдлага

**Боловсрол:**

1987-1992 он Хилийн Цэргийн Командын Дээд Сургууль - Командын Офицер  
1993-1997 он МУИС, Хууль Зүйн Их Сургууль - Эрх Зүйч  
2000-2004он СЭЗИС- Банкны Удирдлага

**Ажил эрхлэлт ба ажлын туршлага:**

1997-2009 он Худалдаа Хөгжлийн Банк, Хуульч, Ахлах хуульч, Газар Хэлтсийн дарга  
2013 оноос одоог хүртэл Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Хуульчдын холбоо- Өмгөөлөгч

2018 оноос “Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн



**ЧАНСАА ЗОРИГТБААТАР**

**Мэргэжил:** Хуульч, Эдийн засагч

**Боловсрол:**

Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль- Банк, Санхүүгийн Эдийн Засгийн Баклавр

МУИС, Хууль Зүйн Их Сургууль- Хууль Зүйн Магистр, Эрх Зүйч

**Ажил эрхлэлт ба ажлын туршлага:**

1996-1997 он Төрийн Өмчийн Хороо- Хуулийн Зөвлөх  
1997-1998 он Хууль Зүйн дунд Сургууль – Хичээлийн эрхлэгч  
1998-2007 он Монгол Банк – Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

2008 он Лекс Коунсел ХХК- Гүйцэтгэх захирал

2018 оноос “Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн



## ТҮВШИНТӨРИЙН ЦЭНД-АЮУШ

### Мэргэжил:

Бизнесийн удирдлага, Компанийн засаглалын эксперт, Эдийн засагч

### Боловсрол:

2000-2012 он МУИС- Бизнесийн Удирдлага

1998-1999 он МУИС- Эдийн засгийн ухааны магистер

1988-1992 он МУИС- ЭЗФ, Үйлдвэрлэлийн удирдлага ба эдийн засгийн бакалавр

### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1993-2005 он СЭЗДС-ийн Багш

2006-2008 он Зөвлөгөө өгөх төвийг хариуцсан СЭЗДС-ийн дэд захирал

2007-2009 он Амжилтын хөтөч ТББ-ийн Гүйцэтгэх захирал

2009-2013 он КЗХТ-ийн ТУЗ-ийн Нарийн Бичгийн Дарга

2013 оноос одоог хүртэл СЭЗИС-ийн профессор

2016 оноос одоог хүртэл СЭЗИС-ийн КЗХТ-ийн хамтарсан Компанийн засаглалын МВА-ийн хөтөлбөрийн эрхлэгч,

2014 оноос одоог хүртэл СЭЗИС-ийн ТУЗ-ийн нарийн Бичгийн дарга

2013 оноос одоог хүртэл КЗХТ-ийн Гүйцэтгэх захирал



## ПҮРЭВСҮХ НИЯМДОРЖ

### Мэргэжил:

Багш, Бизнесийн удирдлага

### Боловсрол:

1996-2000 он Шонхор дээд сургууль - Багш

2008-2009 он Удирдлагын академи- Бизнесийн удирдлага

### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

2008 он Наран очир эрдэнэ ХХК - Захирал

2011-2012 он MWTS ХХК- Брокер

2013-2015 он Гацуурт трейд ХХК- Ахлах Брокер

2015 - он Монголын хөрөнгийн бирж ТӨХК- Маркетингийн мэргэжилтэн

❖ **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН  
ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТОВЧ  
НАМТАР**



**ЛХАГВАЖАВ АРИУНБОЛД**

**Мэргэжил:**

Цахиурын исэлд суурилагдсан эрдсийн хайлах болон дулаанаар боловсруулах технологийн үйлдвэрийн инженер,  
Эдийн Засагч,  
Аж Үйлдвэрийн гавьяат ажилтан

**Боловсрол:**

ЗХУ-ын Свердловскийн Уралын Политехникийн дээд сургуулийн “Силикатын технологи”-ийн факультет,

АНУ-ын Колорада Эдийн засгийн их сургууль,

ОХУ-ын Уралын Холбооны Их Сургуулийн Эрдмийн зэрэг хамгаалах зөвлөл-Эрдэс хайлуулах Вагранка зуухны модернизацийн шинэчлэл сэдвээр Ph.D Доктор зэрэг хамгаалсан,

Техникын Ухаан Доктор,

**Ажил эрхлэлт ба ажлын туршлага:**

1987-1990 онд БЦУГ-ын Засвар механикийн заводад Ерөнхий механик, Ерөнхий инженер,

1990-1993 онд Автомашины салхины шилний Төслийн удирдагч, Төслийн үр дүнд Автомашины салхины шилний үйлдвэр “Чин” ХХК байгуулагдсан.

1999-2012 онд “Мөншил” төслийн удирдагч, Төслийн үр дүнд Шилэн лонхны үйлдвэрийн төсөл

2005 оноос чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрийн төслийг санаачлагч, төслийн удирдагч,

2007-2018 онд “Монгол Базалт” компанийн үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал

2018 оноос “Монгол Базалт” ХК-ийн ТУЗ-ийн дарга



**ГАЛБАДРАХ ГАНЗОРИГ**

**Мэргэжил:**

Цэргийн командлагч, Улс төр судлаач

**Боловсрол:**

1976-1980 Одессит ЦНДС

1990-1992 Улс төрийн их сургууль

2006-2008 БХИС-Удирдлагын академи

**Ажил эрхлэлт ба ажлын туршлага:**

1980-1984 Ардын армийн 138 дугаар ангид- Салааны захирагч

1984-1988 Ардын армийн 138 дугаар ангид- ЗАБ-ын ахлах офицер

1988-1992 Ардын армийн 138 дугаар ангид- Дайчилгаа эрхэлсэн штабын офицер

1992-1994 Зэвсэгт хүчний 084 дүгээр ангид- Штабын орлогч

1994-1997 Нийслэлийн Цэрэг иргэний хамгаалалтын хэлтэст-Шуурхай албаны офицер

1997-2008 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт-Тоо бүртгэл, нөхөн хангалтын офицер

2008-2011 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт- Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан ахлах офицер

2011-2013 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт- Цэргийн штабын орлогч дарга

2016-оноос “Монгол Базальт” ХК Шугам хоолой дэд бүтцийн дулаалгын төслийн багийн удирдагч

2018 оноос “Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн

**HAN KYU BONG /ХАН ГЮ БУНГ/**



**Мэргэжил:**

*Бизнес удирдлагын мастер*

**Боловсрол:**

1981-1985 БНӨСУ-н Их Сургууль –Бизнес Удирдлагын Бакалавр

2007 БНӨСУ-н Их Сургууль – Бизнес удирдлагын Мастер

**Ажил эрхлэлт ба ажлын туршлага:**

1999-2006 Hyundai, салбарын дарга,

2006- 2013 Гаули Инвестмент, гүйцэтгэх захирал,

2013- хойш Гаули ҮЦК, гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Тэрбээр үнэт цаасны зах зээл дээр нийт 32 жил ажилласан туршлагатай бөгөөд БНӨСУ-ын ҮЦЗЗ дээр 2,3 их наяд вонын хөрөнгийг татан төвлөрүүлсэн, МУ-ын ҮЦЗЗ дээр 127 тэрбум төгрөгийг санхүүжилтийг татан төвлөрүүлсэн байна.

2019 оноос “Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн



**ПҮРЭВБАНЗРАГЧ САЙНБИЛЭГ**

**Мэргэжил:** Технологийн Инженер, Санхүүч

**Боловсрол:**

ПТДээд сургууль- Технологийн Инженер

СЭДС- Банк зээлийн эдийн засагч –Санхүүч

**Ажил эрхлэлт ба ажлын туршлага:**

2007-2018 “Монгол Базальт” ХК-ийн Санхүү Хариуцсан захирал 2018 оноос “Дулаан Техникийн Шинэчлэлийн Төв” ХХК эрчим хүчний аудитын байгууллагын Санхүү Хариуцсан Захирал

2018 оноос “Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн



## **БАДАРЧ ШАРАВСАМБУУ**

### **Мэргэжил:**

Нягтлан бодогч, Гавьяат Эдийн засагч

### **Боловсрол:**

1965-Улаанбаатар худалдааны Техникум-

1975- Улс Ардын Аж Ахуйн Дээд Сургууль-

Москва хотын Маркетинг, Эрэлт Судлалын хүрээлэнгийн Эрдмийн Зэрэг Хамгаалах зөвлөлд- Монголын Хэрэглэгчийн Зах Зээлийн Өөрчлөн байгуулалтын асуудлаар PhD Доктор цол, Эдийн Засгийн Ухааны Доктор

### **Ажил эрхлэлт ба ажлын туршлага:**

1965-1970 он Толгойт төв бараа бааз- Тооцооны ахлах орлогч Нябо

1975-1979 он Худалдаа Бэлтгэлийн Яам- Ахлах Мэргэжилтэн, газрын дарга

1979-1984 он Худалдаа Бэлтгэлийн Яам- Орлогч Сайд

1984-1990 он Худалдаа Бэлтгэлийн Яам- Сайд

1990-он Сайд нарын Зөвлөлийн - Орлогч Дарга

1991-1994 он Москва-д Суугаа ЭСЯ-1-р Нарийн Бичгийн Дарга

1994-1996 он Гаалийн Ерөнхий Газар- Дарга

1996-1998он Улаанбаатар Импекс Компани- ТӨ УҮГ- Ерөнхий захирал

1996-2000 он Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль- Маркетингийн Тэнхимийн Эрхлэгч

2000-2004 он Улсын Их Хурлын Гишүүн

2005-2011 он Санхүүгийн Зохицуулах Хороо- Орон тооны Гишүүн, Дэд дарга

2019 оноос “Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн



## АРИУНБОЛД ЭНХГЭРЭЛ

### Мэргэжил:

Үйлдвэр Үйл ажиллагааны Менежмент,  
Санхүү Менежмент,  
Dale Carnegie Mentor Coach,  
Harvard Management Mentor

### Боловсрол:

2014 – 2017 СЭЗИС-Санхүү Менежмент  
2008 – 2011 Лондон Метрополитан Их  
Сургууль-Үйлдвэр Үйл ажиллагааны  
Менежмент

### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

2008 – 2011 Лондон, “ЛУКСОТИКА” компанийн Кингстон салбарын Менежер

2011 - 2012 “Мянганы Сорилтын Сан” – Crown Agents- Худалдан Авах Газрын Менежер

2013 – 2017 “Монгол Базальт” ХК Олон улсын төсөл хариуцсан Захирал

2017 – 2018 “Монгол Базальт” ХК –н ТУЗ-н гишүүн, Үнэт Цаас Хариуцсан мэргэжилтэн

2018 – оноос “Монгол Базальт”ХК-н Гүйцэтгэх Захирал

**“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ/төсөл/**

---

2021 оны 04 сарын 26 -ны өдөр

Дугаар №1

Улаанбаатар хот

*Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд  
Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.11-д заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:

А.ЭНХГЭРЭЛ



**“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ/төсөл/**

---

2021 оны 04 сарын 26 -ны өдөр

Дугаар №2

Улаанбаатар хот

*“Монгол базальт” ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.1-д заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн эхийн хавсралтаар баталсугай.
2. “Монгол базальт” ХК-ийн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:

А.ЭНХГЭРЭЛ

“Монгол базалт” ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлт

№	Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт орсон байдал
1	6.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.	6.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зайнаас / мэдээллийн технологи, дрограмм хангамж ашиглан хурлын бүх үйл ажиллагааг цахимаар/ болон хосолсон /танхим болон цахимаар/ хэлбэрээр зохион байгуулж болно.
2		6.1.21 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахдаа мэдээллийн технологийн зохих туршлага бүхий компанитай гэрээ байгуулж хамтран ажиллана. Энэ тохиолдолд хуралд оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүй үнэн зөв илэрхийлэх боломжтой программыг бүтээх үүргийг мэдээллийн технологийн компани хариуцна. Түүнчлэн мэдээллийн технологийн компани нь энэхүү үүргээ баталгаажуулсан баталгаа бүхий албан бичгийг компанид хүлээлгэн өгнө.
3		6.1.15 Зайны болон хосолсон хурлын материал, хурлын үйл явцын бүтэн дүрс бичлэг, санал хураалтын баримт зэргийг засварлах, өөрчлөх боломжгүй хэлбэрт шилжүүлэн компанийн цахим архивын баримт болгож хадгална.
4		6.1.16 Хурлыг хуралдуулах боломжгүй техникийн нөхцөл үүссэн тохиолдолд хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг ТУЗ товлоно.
5	6.2.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь ердийн, 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 1 жил байна.	6.2.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь ердийн, 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2 жил байна. ТУЗ-ийн гишүүдийг хэдэн ч удаа улируулан сонгож болно.
6	6.2.6.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх	6.2.6.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах хэлбэр сонгох, хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх
7		6.2.71 ТУЗ-ийн хурлыг видео конференцийн хэлбэрээр эсхүл ТУЗ-ийн гишүүдийн албан ёсны цахим хаягаар мэдээлэл солилцох хэлбэрээр саналыг нь авах замаар эчнээ хэлбэрээр явуулж болно. Энэ тохиолдолд ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга нь гишүүдийг тухайн хуралд оролцох, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, санал хураалтад оролцох боломжоор хангаж ажиллана.
8	6.2.8 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал /гүйцэтгэх удирдлага/ болон энэ дүрэмд заасан бусад этгээдийн санаачлага, шаардлагаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.	6.2.8 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал /гүйцэтгэх удирдлага/ болон энэ дүрэмд заасан бусад этгээдийн санаачлаг, шаардлагаар хуралдуулна.

**“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ/төсөл/**

2021 оны 04 сарын 26 -ны өдөр

Дугаар №3

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай*

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7-д заалт, “Монгол Базалыт” ХК-ийн дүрмийн 6.1.5.9-д заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базалыт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр
  - 1.1. \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_
  - 1.2. \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_
  - 1.3. \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_
  - 1.4. \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_
  - 1.5. \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_
  - 1.6. \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ - нарыг тус тус сонгосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр
  - 2.1. \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_
  - 2.2. \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_
  - 2.3. \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ - нарыг тус тус сонгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон бусад хууль тогтоомжийг баримтлан компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:

А.ЭНХГЭРЭЛ

**“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ/төсөл/**

---

2021 оны 04 сарын 26 -ны өдөр

Дугаар №4

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын  
хэмжээг тогтоох тухай*

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13-д заалт, “Монгол Базалт” ХК-ийн дүрмийн 6.1.5.15-д заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базалт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг сар бүр тооцон, хууль тогтоомжийн дагуу олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Б.Болортуяа/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА:

А.ЭНХГЭРЭЛ

*“Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын 4 тоот тогтоолын хавсралт*

**“Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ**

ТУЗ-ийн гишүүдийн цалин		Хэмжээ /төгрөг/
Тогтмол цалин	Үндсэн	1,000,000 ₮
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	200,000 ₮
	Хорооны даргын нэмэгдэл	100,000 ₮
Оролцоонд үндэслэсэн нэмэгдэл цалин	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд биечлэн оролцсон тоогоор	100,000 ₮

Хурлууд:	Хурлын давтамж, тоо
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	Жилдээ 1 удаа
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал	Жилдээ 4 удаа
ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны хурал	Жилдээ 4 удаа
ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны хурал	Жилдээ 2 удаа
ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны хурал	Жилдээ 1 удаа

*“Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2021 оны 03 сарын 15-ний өдрийн 05 тоот тогтоолын Хавсралт № 3*

**“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК- ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог .....нэр.....

Регистрийн дугаар: 

--	--	--	--	--	--	--	--	--	--

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд**

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог.....нэр.....

Эзэмшиж буй хувьцааны тоо: .....

Санал өгөх хувьцааны тоо: .....

Брокерийн компанийн нэр: .....

*“Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 сарын 26-ны  
өдрийн 16.00 цагт MI SURVEY програм ашиглан цахимаар хийнэ.*

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн болон тайлан, хараат бус аудиторын дүгнэлт, ТУЗ-ийн дүгнэлт			
2	“Монгол базальт” ХК-ийн шинэчилсэн дүрэм			
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох			

*(Та саналыг хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг + тэмдгийг бичнэ үү )*

Хувьцаа эзэмшигч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийн ..... Гарын үсэг

Саналын хуудасыг хүчинтэйд тооцсон эсэх: .....

Тооллогын комиссын дарга ..... /Ц.Байгалмаа/

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан: .....

Санал авах хуудас үйлдсэн: 2021 оны . . . сарын . . . өдөр

**САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ**

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт +/- тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн хүснэгтэд +/- тэмдэглэгээ хийнэ.
2. Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
3. Засварласан, балласан залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчид нь 2021 оны 04 сарын 08-ны дотор хурлын материалтай танилцах бөгөөд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд 2021 оны 04 сарын 08-ны 18.00 цагаас өмнө санал авах хуудсанд саналаа тэмдэглэн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хүргүүлнэ.

**“Монгол Базальт” ХК- ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын**

# МОНГОЛ БАЗАЛЫТ ХУВЬЦААТ КОМПАНИ

“Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2021 оны 03 сарын 15-ний өдрийн 05 тоот тогтоолын Хавсралт № 4

## “МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК- ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог .....нэр.....

Регистрийн дугаар:

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд**

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог.....нэр.....

Эзэмшиж буй хувьцааны тоо: .....

Санал өгөх хувьцааны тоо: .....

Брокерийн компанийн нэр: .....

“Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 сарын 26-ны өдрийн  
16.00 цагт MI SURVEY программ ашиглан цахимаар хийнэ.

№	Хэлэлцэх асуудлууд	Туз-ийн гишүүнд нэр дэвшигч	Саналын эрхийн тоо
1	ТУЗ-ийн ердийн гишүүнийг сонгох		
2	ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох		
3	Саналын эрхийн тоо		

(Та саналыг хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг + тэмдгийг бичнэ үү)

### КУМУЛЯТИВ АРГААР САНАЛ ХУРААХ ЖИШЭЭ:

Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл ТУЗ нь 9 гишүүнтэй байхад 100 ширхэг энгийн хувьцаа нь 900 саналын эрхтэй /100\*9=900/ болох бөгөөд 600 саналын эрхээр ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид санал өгөх, 300 саналын эрхээр ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид санал өгөх эрхтэй болно.

Хувьцаа эзэмшигч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийн ..... Гарын үсэг

Саналын хуудсыг хүчинтэйд тооцсон эсэх: .....

Тооллогын комиссын дарга ..... /Ц.Байгалмаа/

Саналын хуудасыг хүчингүйд тооцсон шалтгаан: .....

Санал авах хуудас үйлдсэн: 2021 оны . . . сарын . . . өдөр

### САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудасыг бөглөхдөө санал өгөх хэсэгт +/- тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн хүснэгтэд +/- тэмдэглэгээ хийнэ.
2. Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
3. Засварласан, балласан залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчид нь 2021 оны 04 сарын 08-ны дотор хурлын материалтай танилцах бөгөөд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд 2021 оны 04 сарын 08-ны 18.00 цагаас өмнө санал авах хуудсанд саналаа тэмдэглэн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хүргүүлнэ.









"Фламинго Тауэр" 7 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Улаанбаатар хот, Монгол улс



7511-4444



[www.basaltwool.mn](http://www.basaltwool.mn)



[monbasalt@rockwool.mn](mailto:monbasalt@rockwool.mn)



Mongol Basalt JSC



@Mongol\_Basalt



Mongol\_Basalt